



USAID
FROM THE AMERICAN PEOPLE




The Asia Foundation



ЦЭЦЭРЛЭГИЙН САЙН ЗАСАГЛАЛ БА МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Цэцэрлэгүүдийн сайн арга туршлагаас



Улаанбаатар 2014 он

Гарын авлага боловсруулсан:

Б.Эрдэнэчимэг	МОНЭС-гийн Гүйцэтгэх захирал
В.Удвал	Эмэгтэй Удирдагч сангийн Удирдах Зөвлөлийн дарга
Ц.Цэвэлмаа	Нийслэлийн 22-р цэцэрлэгийн эрхлэгч
Ц.Ганчимэг	Нийслэлийн 22-р цэцэрлэгийн нярав
Т.Чинбат	Нийслэлийн 22-р цэцэрлэгийн арга зүйч
М.Сарантуяа	Нийслэлийн 76-р цэцэрлэгийн эрхлэгч
С. Цэрмаасүрэн	Нийслэлийн 76-р цэцэрлэгийн нягтлан бодогч
Ж.Буянжаргал	Нийслэлийн 76-р цэцэрлэгийн арга зүйч
Б.Бямбасүрэн	Нийслэлийн 189-р цэцэрлэгийн эрхлэгч
Д.Мөнхжаргал	Нийслэлийн 189-р цэцэрлэгийн нягтлан бодогч
Р.Энхмөнх	Нийслэлийн 189-р цэцэрлэгийн багш
Н.Өлзийхутаг	Нийслэлийн 2-р цэцэрлэгийн эрхлэгч

Хянан тохиолдуулсан:

В.Удвал “Үйлчилгээгээ өөрсдөө хяная” төслийн зөвлөх, Эмэгтэй Удирдагч сангийн Удирдах зөвлөлийн дарга

Энэхүү гарын авлагыг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Азийн сангийн санхүүгийн дэмжлэгтэй боловсруулсан болно. Гарын авлага нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Азийн сангийн үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

Агуулга

Өмнөх үг	04
Нэг. Цэцэрлэгийн Сайн засаглал	07
Хоёр. Мэдээллийн ил тод байдлыг хангах хууль эрх зүйн орчин	11
Гурав. Цэцэрлэгийн ил тод байдлыг үнэлэх нь	17
Дөрөв. Цэцэрлэгийн үйлчилгээний ил тод байдлыг хангах нь	25
Тав. Цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг сайжруулахад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх нь	29
Дүгнэлт	32
Ашигласан материал	33

Өмнөх үг

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэжээ. Ардчилсан нийгэмд төрийн үйлчилгээг иргэдийн орлогоос үл хамааран хүн бүр тэгш хүртэх асуудлыг хуулиар тогтоодог. Монгол Улсын иргэн тэгш, шударга хүртэх ёстой үйлчилгээний нэг нь цэцэрлэгийн үйлчилгээ юм.

Боловсролын үйлчилгээний анхан шатны нэгж болох цэцэрлэгт мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулах зорилгоор АНУ-ын Олон улсын Хөгжлийн агентлаг, Азийн сангийн дэмжлэгтэй Монголын эмэгтэйчүүдийн сан, Эмэгтэй Удирдагч сан хамтран 2013 оны 03-р сараас “Монгол Улсад Засаглал, Ил тод байдлыг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Үйлчилгээгээ өөрсдөө хяная” төслийг нийслэлийн 2, 22, 76, 189 цэцэрлэгт эхлүүлсэн юм. Төсөл нь мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг тухайн цэцэрлэг дээр хэвшүүлж, эцэг эхчүүдийг цэцэрлэгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулахыг зорьсон юм.

Төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй болгох нэг чухал хүчин зүйл нь мэдээллийн тод байдал гэдгийг төсөлд хамрагдсан цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа харуулсан юм. Төрийн үйлчилгээний анхан шатны нэгж болох цэцэрлэг

мэдээллээр иргэдийг хангаснаар өөрийн үйл ажиллагааг үнэлэх, алдаа доголдол, амжилт байгааг олж харж, төрийн үйлчилгээг сайжруулах нэг боломж байгаа нь харагдлаа.

Төсөл хэрэгжүүлэх явцад цэцэрлэгүүд хуримтлуулсан арга туршлагаа Улаанбаатар хотын 4 дүүргийн нийт 110 цэцэрлэгт түгээн дэлгэрүүлэх сургалтууд явуулсан ба сургалтын агуулга дээр үндэслэн энэхүү гарын авлагыг боловсрууллаа.

Төрийн анхан шатны үйлчилгээний нэгж болох цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг сайжруулахад энэхүү гарын авлага цэцэрлэгүүд болон энэ асуудлыг сонирхож байгаа байгууллагуудад тус дэм болно гэдэгт итгэлтэй байна.

Зохиогчид



НЭГ | ЦЭЦЭРЛЭГИЙН САЙН ЗАСАГЛАЛ

1

Засаглал ба сайн засаглал

Засаглал гэж байгууллагын хүрээнд эрх мэдэл, хяналт хэрхэн хэрэгжиж, хэрхэн хуваарилагдсан байдлыг хэлнэ. Засаглал нь үр дүнтэй, шударга байж, хуулийг дээдлэх зарчмыг баримталдаг. НҮБХХ нь засаглалыг төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хоорондын харилцаагаар дамжуулан өөрийн улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн харилцааг зохицуулах тогтолцоо хэмээн тодорхойлсон байна.

Засаглал нь иргэд болон нийгмийн бүлгүүд ашиг сонирхол, өөр хоорондын ялгаатай байдлаа илэрхийлэх, хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх үйл явцаас бүрддэг. Тухайлбал, хувь хүн, байгууллага, компаниудын үйл ажиллагаанд зарим төрлийн хязгаарлалт тогтоох, эсвэл урамшуулал бий болгох, хүний эрхийг хамгаалах дүрэм, журам, институци, практикийг бий болгодог.

Сайн засаглал гэдэг нь эрх мэдэл, хяналтын тогтолцоо нь ганц нэг хүн эсвэл хэсэг бүлгийн хүрээнд төвлөрөөгүй байх нөхцөл бүрдүүлэхийг хэлнэ. Энэ нь эрх мэдэл, хяналтыг байгууллагын хүрээнд байх ёстой газарт нь байлгахыг шаарддаг бөгөөд ингэснээр эрх мэдлийг менежмент болон удирдах зөвлөл зэрэг олон хүмүүст тэгш хуваарилах, мөн тэдний хүлээх хариуцлагыг тодорхой болгох боломжийг бүрдүүлнэ. Тэгвэл сайн засаглал улс бүрийн хөгжлийн гарц болох нь тодорхой. НҮБ-гаас Сайн засаглалыг хариуцлага хүлээж тайлагнах ёс, ил тод байдал, иргэдийн оролцоо, хариуцлагатай байдал дээр суурилсан удирдлага гэж тодорхойлжээ.



Дээрх тулгуур ойлголтууд сайн засаглалыг бүрдүүлэхэд ямар үүрэгтэй вэ?

Ил тод байдал – Төсөв, төсвийн гүйцэтгэл, тайланг санхүүжүүлэгч, ашиг хүртэгчдээр нь гарган олон нийтэд ил тод болгох. Үйл ажиллагаа, санхүү, төсөв ил тод байх тусам хариуцлага хvlээх чадвар өндөр байхыг шаарддаг. Хариуцлага хvlээх чадвар нь ил тод байдлыг хөгжүүлэх нөхцөл нь болно. Ил тод байдал нь олон нийт төрийн удирдах албан тушаалын хvmүүстэй харилцах нээлттэй суваг, нээлттэй мэдээллийн урсгалыг бий болгосноор тэдний хооронд хамтын ажиллагааны тааламжтай орчин бүрдэнэ. Энэ нь төрийн үйлчилгээ авч байгаа иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болно.

Иргэдийн оролцоо – Байгууллагын үйл ажиллагаа, засаглалын хүрээний бүхий л түвшинд шийдвэр гаргах үйл явцад эрх ашиг нь хөндөгдөх бүхий л талуудыг оролцуулна. Оролцооны иж бүрэн үйл явц нь хамтын хэлэлцүүлэг, дүн шинжилгээ, үйл ажиллагааны хэрэгжилт болон түүний эргэх холбооноос бүрдэнэ. Талуудын тэгш оролцоог хангах нь төвлөрлийг сааруулах үйл явцыг дэмжиж байдаг. Энэ нь шийдвэр гаргахад оролцох, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хуулийн өмнө бүх хvн ижил тэгш байх зэрэг хүний эрхийн vндсэн зарчмуудын төлөвшилтөөр тодорхойлогддог.

Хариуцлагатай байдал: Хариуцлага гэдэг нь хэн нэгэн хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх, түүнийхээ төлөө хариулт өгөх чадвартай, хариуцлагаа хүлээх чадвартай байх бөгөөд өөрөөр хэлбэл нөөцийг ухаантай зарцуулж, эрхэм

зорилготой зөрчилдсөн ямар нэгэн үйл ажиллагаа явуулахгүй байхыг хэлнэ.

Дээрх тулгуур ойлголтуудыг нэгтгэж үзэхэд “Сайн засаглал” нь нээлттэй ил тод, эрх зүйт засаглал, хуулийн хүрээнд байж аливаа шийдвэрийг гаргахдаа оролцоонд түшиглэсэн, хариуцлагын тогтолцоо нь оновчтой, тодорхой байдгаараа онцлог юм.

Цэцэрлэгийн Сайн засаглал

Төрийн үйлчилгээний анхан шатны нэгж болох цэцэрлэгийн Сайн засаглал гэдэг нь өргөн утгаараа аливаа шийдвэр гаргах үйл ажиллагаанд хүүхэд, эцэг эх, орон нутгийн байгууллага, иргэний нийгмийн бүлгүүдийн оролцоог дээд зэргээр хангасан /нээлттэй/ хариуцлагатай боловсролын удирдлагын тогтолцоог хэлнэ



Үйл ажиллагаа нь хичнээн ил тод байх тусам хариуцлага хүлээх чадвар өндөр байхыг шаарддаг. Харин хариуцлага хүлээх чадвар нь ил тод байдлыг хөгжүүлэх нөхцөл нь болно.

Сайн арга туршлага.

Төслийн багийнхан Сайн засаглалын нэг тулгуур багана болох мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хөгжүүлэх цэцэрлэгүүдийг нутаг дэвсгэрийн байршил, тухайн асуудлаар хуримтлуулсан арга туршлага, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах хүсэл, сонирхлыг шалгуур болгон сонгосон юм. Энэ шалгуурын дагуу хотын захын гэр хорооллын, шинээр байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн Хан-Уул дүүргийн Яармагийн 189 дүгээр цэцэрлэг, өдрийн болон 24 цагийн бүлэгтэй

Баянгол дүүргийн 76 дугаар цэцэрлэг, “Шилэн түрийвч” төсөлд хамрагдсан төсвөө ил тод байрлуулсан, өөрийн цахим хуудастай орчин үетэй хөл нийлүүлж яваа Баянзүрх дүүргийн 22 дугаар цэцэрлэг, хотын төвд байрлалтай гэсэн онцлогтой Сүхбаатар дүүргийн 2-р цэцэрлэгүүд сонгогдсон юм. Төслийн багийн гишүүдийг цэцэрлэгүүд эхэндээ ажил хянах уу, цэцэрлэгийн ил тод, нээлттэй байдлыг хөгжүүлэхэд хүссэн үр дүнд энэ богино хугацаанд хүрэх үү гэх мэт олон асуулт тавин угтсан билээ.

Иймд төслийн багийн гишүүдийн баримталсан гол чиглэл:

Харилцан ойлголцох, зөвшилцөх, мэдээллийн ил тод байдлаа хөгжүүлэхийг сэдэлжүүлэх

Цэцэрлэгүүд дээр ил тод байдлыг хөгжүүлэхийг цэцэрлэгүүд өөрсдөө хариуцах

Цэцэрлэгүүдэд харилцан суралцах боломж олгох, сайн арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх

Эцэг эхчүүдийн мэдээллийн ил тод байдлын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлсний үндсэн дээр авч байгаа үйлчилгээний чанарыг сайжруулахад оролцоог нэмэгдүүлэх

Сайн засаглалыг хөгжүүлэхэд цэцэрлэгүүдийн оруулсан хувь нэмэр

Бүтээлч харилцаа тогтоож “Харилцан ойлголцлын Санамж бичиг” байгуулан төслийн хүрээнд хамтран хийх ажлын талаар зөвшилцсөн.

Сайн засаглалын тулгуур баганы нэг болох Мэдээллийн ил тод байдал цэцэрлэгүүд дээр ямар байгаад үнэлгээ хийх, сайжруулах алхмаа үйлчлүүлэгчидтэйгээ хамтарч шийдвэрлэсэн

Үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцсэн бодит мэдээллийг ил тод болгохыг зорьж ажилласан

Мэдээллийн ил тод байдлын асуудлаар үйлчлүүлэгчид болон ажиллагсадын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлсэн

Мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулсан

Эцэг эхийн сургалтын орчныг сайжруулахдаа дэмжигч оролцооноос үйлчилгээгээ үнэлдэг, хянадаг, сайжруулахыг шаарддаг оролцооны талаар мэдлэгийг нэмэгдүүлсэн

Эцэг эхийн мэдээллийг сонирхдог оролцооноос хэрэгтэй мэдээлэл тавихыг шаарддаг, хүсдэг, дүн шинжилгээ хийдэг оролцоог хөгжүүлэх эхлэлийг тавилаа.

ХОЁР | МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2011 онд батлагдаж, 2012 оноос эхлэн хэрэгжиж байгаа “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуульд төрийн бүх байгууллага мэдээллээ ил тод байлгах үүрэг хүлээсэн байна. Иймд эцэг эхчүүд хуулиа хэрэгжүүлэхийг шаардаж тухайн цэцэрлэгийн бүхий л үйл ажиллагааны талаар мэдээлэл авах эрхтэй. Мөн 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д Монгол Улсын иргэн “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэжээ. Иргэн хүний мэдээлэл авах эрх, төрийн үйлчилгээг адил тэгш хүртэх эрх, байгууллагын талаарх ямар мэдээлэл ил тод байх тухай хууль эрх зүйн баримт бичгийн тухай мэдлэг, мэдээлэл нь иргэний мэдэх эрх болон хүссэн мэдээллээ олж авах эрхийг баталгаажуулж байгаа билээ

Төрийн анхан шатны үйлчилгээний нэгж болох цэцэрлэгүүд ч үйлчилгээгээ иргэдийн татвар төлсөн мөнгөөр үзүүлж байгаа учир хэрэгцээтэй мэдээллийг эцэг эхчүүдэд түгээх үүрэг хүлээж байна.

Иймд төрийн байгууллагын үйлчилгээ нь:

- Олон нийтэд тэгш, хүртээмжтэй
- Иргэддээ нээлттэй, хүнд сурталгүй
- Иргэдийнхээ нийтлэг эрх ашигт нийцсэн байх ёстой.

Энэ шаардлага ч цэцэрлэгүүдэд хамаатай. Мэдээллийн ил тод, нээлттэй байдал нь төрийн байгууллагын үйл ажиллагааг үр ашигтай болгох, үргүй зардлыг ил гаргах, авлигал хээл хахуулийг зогсоох, бодлогын алдаа дутагдлыг ужгирч газар авахаас өмнө олж тогтооход хувь нэмрээ оруулдаг юм.

Мэдээлэлгүй иргэд төрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, оролцож чадахгүй. Үнэн зөв, бүрэн дүүрэн мэдээлэлтэй байснаар иргэд төрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнтэй оролцож, үйлчилгээг сайжруулахыг шаардаж, ингэснээр төрийн үйлчилгээ нь иргэддээ түргэн, шуурхай, ямар нэгэн хүнд сурталгүй хүрэх боломжтой. “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу төрийн байгууллагууд иргэдэд ил тод, нээлттэйгээр хүргэх үүрэгтэй мэдээллийг зааж өгсөн байна.

“Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай” хууль

“Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай” хуулинд зааснаар төрийн байгууллага нь дараахь мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээсэн.

Үүнд:

Үйл ажиллагаа

Хүний нөөц

Төсөв санхүү

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа



1. Үйл ажиллагааны ил тод байдал

Эрхэм зорилго

Үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго

Тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн

Зохион байгуулалтын бүтцийг цахим

хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх явдал юм.

2. Хүний нөөцийн ил тод байдал

Ажлын байрны сул орон тооны
талаарх мэдээлэл
Албан хаагчийн ёс зүйн дүрэм
Хүний нөөцийн стратеги, энэ талаар
хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны
чиглэл
Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн
үнэлгээ



3. Төсөв санхүүгийн ил тод байдал

Тухайн жилийн төсөв
Урьд оны төсвийн гүйцэтгэл
Дараа жилийн төсвийн төсөл
Төсвийн гүйцэтгэл
Жилийн эцсийн санхүүгийн
тайлан
Аудитын тайлан
Төсөвт оруулсан өөрчлөлт
Хуульд тогтоомжид заасан

үйлчлүүлэгчээс авах хураамжийн хэмжээ

4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалданавах үйл ажиллаганы ил тод байдал

Тендерийн баримт бичиг, тендер
шалгаруулалтыг явуулах журам
Тендерт оролцохыг сонирхогчид
тавих шалгуур үзүүлэлт,
шалгаруулсан талаарх мэдээлэл
Худалдан авсан бараа, ажил,
үйлчилгээний тайлан



“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу дээрх мэдээллийг төрийн байгууллага нь иргэдэд хүртээмжтэй байдлаар, хуулинд заасны дагуу мэдээллийн самбар болон цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагаагаа иргэдэд ил тод мэдээлэх үүрэг хүлээсэн байна.

Мэдээллийг түгээх

Төрийн байгууллагын мэдээлэл түгээх арга хэрэгсэл

Төрийн байгууллага, албан тушаалтан мэдээллийг түгээхдээ хууль тогтоомжид заасан дараах арга хэлбэрийг ашиглах үүрэг хүлээсэн байдаг.



Амаар болон бичгээр хариу өгөх



Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах



Мэдээллийн самбар ашиглах



Цахим хуудаст байршуулах

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу цэцэрлэгүүд дээр байх мэдээлэл

Цэцэрлэгийн үйлчилгээ нь өөрийн онцлогтой. Үзүүлж байгаа үйлчилгээний ил тод байдлыг үйлчлүүлэгчдийн асран хамгаалагчид дүгнэнэ. Бага насны хүүхдийн хөгжил, хамгаалал, эрүүл аюулгүй байдал, хүүхдийн насанд тохирсон хоол, ундаар хангах гээд маш олон төрлийн үйлчилгээ үзүүлнэ. Үзүүлж байгаа үйлчилгээний онцлогоос хамаарч дараахь нэмэлт мэдээлэл ил тод байх нь үйлчүүлэгчдэд хэрэгтэй гэсэн санал гарсан юм.



Үйл ажиллагааны ил тод байдал

Эцэг эх, багшийн Харилцах дэвтэр
Ангиудын байдлыг ил тод харуулж байх камер



Төсөв

Энгийн ойлгомжтой, сонирхолтой



Худалдан авалт

Цэцэрлэгийн хүнсийг худалдан авч байгаа орон нутгийн өмчит үйлдвэрийн газартай байгуулсан гэрээ Хүүхдүүдийн хэрэглэж байгаа хүнс аюулгүй гэдгийг нотолгоожуулсан шинжилгээний бичиг баримт Хүнсий бүтээгдэхүүний хадгалалт хугацаатай холбоотой мэдээлэл зэрэг



Хүүхдийн хоол

Дээж
Хоолны меню, илчлэг
Амталгаа
Өдөрлөг
Эцэг эхийн санал
асуулга, түүний мөрөөр
хэрэгжүүлсэн үйл
ажиллагаа



Тогоочийн булан

Орц, норм,
Хоолны цэс
Технологийн карт
Материалын тооцоо
Дээж



Эцэг эхээс авсан хандивын зарцуулалтын мэдээлэл

Хандивын зориулалт,
хандив авах хэрэгцээ
шаардлага
Хандивын
зарцуулалтын
мэдээлэл

Шигтгээ

Эцэг эхчүүдэд хэдэн хүүхдийг бүртгэх, таны хүүхэд бүртгэлийн хэддэх дугаарт жагсаж байна, хүүхдийн шилжилт хөдөлгөөнөөс хамаараад хэдийд орон тоо гарах, ямар ур чадвар, туршлагатай багш нар ажиллаж байна гэх мэт хэрэгцээтэй мэдээлэл нь ил тод байдаг бол хонон өнжин дугаарлаж, хэн нэгэн таньдаг хүнийг хайхгүй байх боломж байна. Мэдээллийг ил тод болгосноор цэцэрлэгийн зүгээс хэн нэгнээс авлигал авч хүүхдийг нь оруулсан гэдэг хардлага байхгүй болно. Цэцэрлэгийн захиргааны зүгээс эцэг эхчүүдэд хэрэгтэй мэдээллийг ил тод тавьдаг бол үл ойлголцол, бухимдал, хардлага сэрдлэг үүсэхгүй байх боломж байна.

ГУРАВ

ЦЭЦЭРЛЭГИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ НЬ

Тухайн байгууллага нь мэдээллийн ил тод байдлыг хангаж байгааг үнэлэх нь төрийн байгууллагын үйл ажиллагааг үр ашигтай болгох, үргүй зардлыг ил гаргах, авлигал хээл хахуулийг зогсоох, бодлогын алдаа дутагдлыг ужирч газар авахаас нь өмнө олж тогтоох зэрэгт хувь нэмрээ оруулдаг. Үйлчлүүлэгчиддээ ямар зардал гаргах, үйл ажиллагаагаа ямар дүрэм журмаар зохицуулж байгаагаа мэдээлдэг байх, тэдгээр мэдээллийг авах боломжтой байх, асуудлыг иргэдийн оролцоонд тулгуурлан шийдэж чадаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийснээр мэдээлэл нь ил тод байгаа эсэхийг мэдэж болно.

Цэцэрлэгийн мэдээллийн ил тод байдлыг хангагдаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх ажлаа үе шаттай зохион байгуулах хэрэгтэй. Мэдээллийн ил тод байдал цэцэрлэг дээр ямар байна гэдгийг тодорхойлохын тулд дараахь үйл ажиллагааг үе шаттай хийснээр цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэл тодорхой болно.

Үнэлгээ хийж эхлэхийн тулд:

- Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтүүдээ гаргана
- Шалгуур үзүүлэлтийн дагуу цэцэрлэгийн мэдээллийн ил тод байдлынхаа үнэлгээ хийнэ

Мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд

1

2

3

дараахь үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах нь үр дүнд хүрэхэд чухал ач холбогдолтой. Үүнд:

Эхний шат:

- Мэдээллийн ил тод байдлын талаар цэцэрлэгийн ажиллагсдын өөрийн үнэлгээ
- Хоёрдугаар шат
- Эцэг эхчүүдийн үнэлгээ

Гуравдугаар шат:

- Мэдээллийн чанар, хүртэмжийг сайжруулах талаар цэцэрлэгийн захиргаа, эцэг эхчүүдтэй хамтарсан уулзалт зохион байгуулах

Дөрөвдүгээр шат:

Чанар, хүртэмжийг сайжруулах бодит ажил хийх/аян, өдөрлөг, мэдээллийн шинэчлэл

Тавдугаар шат:

- Эцэг эхчүүдээс санал асуулга авах
- Эцэг эх, цэцэрлэгийн ажилтнуудын уулзалтыг давтан зохион байгуулж, үйлчилгээнийхээ чанарыг дүгнэн ярилцах
- Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах

Зургадугаар шат:

Төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх

Сайн арга туршлага

Мэдээллийн ил тод, нээлттэй байдал өргөн цар хүрээтэй олон асуудал багтаасан байдаг учир төслийн баг нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заагдсан үйл ажиллагааны ил тод байдал, эцэг эхээс авч буй хандивын эргэн тайлагналтын байдал болон мэдээллийн ил тод байдлыг хангахад эцэг эхийн оролцоо ямар байгаад хяналт шинжилгээ хийсэн юм.

Хүснэгт 1. Үнэлгээ хийсэн асуудал

Асуудал	Ил тод байдлыг хянах үзүүлэлтүүд
Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг төрийн үйлчилгээний анхан шатны нэгжид хэрэгжүүлж буй байдал, мэдээллийн хүртээмж	Үйл ажиллагаа Хүний нөөц Төсөв Худалдан авалт Мэдээллийн хүртээмж Мэдээллээ тогтмол, тухай бүр шинэчилж буй байдал
Эцэг эхээс авч буй хандив, буцалтгүй тусламжийн эргэн тайлагналт	Хандивын талаарх эцэг эхчүүдийн ойлголт Тухайн жилд өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандив Буцалтгүй тусламж Эргэн тайлагналт
Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	Цэцэрлэгийн мэдээллийн ил тод байх талаар эцэг эхчүүдийн саналыг судлах

Эцэг эхчүүд болон ажиллагсадаас авсан анхны тандалт судалгаагаар ямар мэдээлэл ил тод байх ёстой талаар тэдний ойлголт, мэдлэг хангалтгүй, цэцэрлэгүүдэд эцэг эхчүүдийн мэдэж байх ёстой хэрэгцээтэй мэдээлэл байхгүй байна гэсэн эхний дүгнэлтийг төслийн баг хийсэн юм.


Нөгөө талаар эцэг эхчүүдэд ямар мэдээлэл хамгийн их хэрэгтэй байдгийг судалж үзэхэд тэдэнд нэн тэргүүнд хүүхдийнхээ сургалттай холбоотой мэдээлэл, сургалтын орчин, идэж байгаа хоолны амт чанар, цэцэрлэгийн эрүүл ахуйтай холбоотой мэдээлэл авахыг хүсч байгааг судалгааны дүн харуулсан юм.

1

2

3

Дүрс 1. Эцэг эхчүүдийн хүсч буй мэдээлэл /345 эцэг эх оролцов/



Цэцэрлэгүүдийн самбарт төрөл бүрийн мэдээлэл тавьдаг ба төслийн баг эдгээр самбарт байршуулсан мэдээллийг цэцэрлэгийн үйл ажиллагаатай холбогдолтой байдал, цаг үеийн шинжтэй мэдээлэл, мэдээллийн эцэг эхчүүдэд хүртээмжтэй болон энгийн, ойлгомжтой байдал гэж ангилан дүн шинжилгээ хийсэн ба эцэг эхчүүдийн сонирхож буй мэдээллийг тэдэнд ойлгомжтой хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэхэд анхаарах хэрэгтэй дүгнэлт хийсэн юм.

Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ

Мэдээллийн ил тод байдал тухайн цэцэрлэг дээр ямар байгаа зайлшгүй үнэлгээгээр тодорхой болох учир цэцэрлэгүүд дээр хийсэн эхний үйл ажиллагаа маань ил тод байдлыг хангаж ажиллаж байгаа байдлыг эцэг эхчүүд болон багш, ажиллагсдаар үнэлүүлсэн юм.

Үнэлгээг өөрийн онцлогтой тохируулан асуулга, үнэлгээний хэрэгслүүдийг ашиглаж хийсэн. Бидний хувьд

Иргэдийн онооны картыг ашиглан мөрдөж байгаа хууль, дүрэм, санал хүсэлтийн мөрөөр авсан арга хэмжээ, багш нарын тухай мэдээлэл, багшийн ёс зүйтэй холбоотой асуудал, төсөв ба гүйцэтгэлийн ил тод байдал, эцэг эхээс авч байгаа хандивын эргэн тайлагналт, засвар үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, сургалтын орчин, хүүхдийн хоолны амт чанар, эрүүл ахуй, ариун цэвэртэй холбоотой мэдээлэл тухайн цэцэрлэг дээр ямар байгаад ажиллагсад болон эцэг эхчүүд оноогоор дүгнүүлсэн юм.

Хүснэгт2. Ил тод байдлыг хангаж ажиллаж байгаа талаар ажиллагсад болон эцэг эхчүүдийн өгсөн онооны харьцуулалт/2013 оны 04-р сар /

Багш, эцэг эхийн үнэлгээний харьцуулалт

Үйл ажиллагаа	45 Багш, ажилчид оноо /хэдэн хувь нь сонгосон /	345 Эцэг эх оноо /хэдэн хувь нь сонгосон /
Мөрдөж байгаа хууль дүрэм журам	81-100 /57,1%/	31-60 /31%/
Санал хүсэлтийн мөрөөр авсан арга хэмжээ	81-100 /45,5%/	30-аас доош /33,9%/
Багш ажилчдын орсон гарсан тухай мэдээлэл	81-100/50,0%/	30-аас доош /59,7%/
Багшийн ёс зүйн дүрэм	81-100 /53,8%/	30-аас доош /39,6%/
Төсөв болон гүйцэтгэлийн ил тод байдал	31-60/41,7%/	30-аас доош /52,7%/
Эцэг эхээс авч буй хандив тусламжийн эргэн тайлагналт	81-100/54,5%/	30-аас доош /31,2%/
Засвар үйлчилгээний мэдээлэл	81-100/46,7%/	30-аас доош /40,2%/
Хөрөнгө оруулалтаар авсан бараа бүтээгдэхүүний тайлагналт	81-100/53,8%/	30-аас доош /44%/
Хүүхдийн хоолны амт чанар, илчлэг, меню	81-100/46,7%/	30-аас доош /33,9%/
Эрүүл ахуй, ариун цэвэр	81-100 /83,3%/	30-аас доош /31,5%/

1

2

3

Иргэдийн онооны карт ашиглан мэдээлийн ил тод байдлын үнэлгээ хийхэд эцэг эхчүүд болон цэцэрлэгийн ажиллагсдын үнэлгээний хооронд маш их ялгаа гарлаа. 100 баллын оноогоор дүгнэхэд цэцэрлэгийн ажиллагсад дунджаар өөрсөддөө 80 оноо өгсөн бол, эцэг эхчүүд 30 оноо өгснийг дээрх хүснэгтээс харж болно. Иймд эцэг эхчүүдийн өгсөн оноог дээшлүүлэхийн төлөө цэцэрлэг үйл ажиллагаагаа нээлттэй болгох хэрэгцээ шаардлага байгаа нь харагдсан юм.



Цэцэрлэгийн захиргаа болон эцэг эхийн зөвлөлдөх уулзалт

Үйл ажиллагааны дараагийн шат бол үнэлгээний дагуу ямар ажил хийх вэ гэдгийгээ үйлчлүүлэгчид тэйгээ хамтран хэлэлцэх, 2 талын тэгш оролцоог хангасан уулзалт зохион байгуулсан. Уулзалтын үеэр байгаа

зүйлийг шүүмжлэхээс илүү нөхцөл байдлыг бүтээлчээр хэрхэн өөрчлөхөд анхаарсан. Уулзалтыг амжилттай зохион байгуулахад 2 талын бүтээлч хандлага чухал үүрэгтэй гэдгийг анхаарсан.

Мэдээллийн ил тод байдал хангалтгүй байгаа үнэлгээ гарсны дараа цэцэрлэгүүд дээр дараахь ажил зохион байгуулсан.

Үүнд:

- Мэдээлийн самбаруудад байршуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шинэчилсэн
- Мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилгоор цахим хуудас ажиллуулсан
- Мэдээллийн ил тод байдлын талаар багш, ажиллагсад, эцэг эхчүүдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтууд зохион

байгуулсан

- Эцэг эхчүүдэд хэрэгцээт мэдээллийг танилцуулах сарын аян, өдөрлөг зохион байгуулсан юм.

Ахиц өөрчлөлтөө үнэлж дүгнэх

Дээрх ажлыг хийснийхээ дараа цэцэрлэгт Мэдээллийн ил тод байдал ямар байгааг дахин үнэлсэн юм. Энэ үнэлгээ нь эцэг эхчүүдэд хүргэж байгаа мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх боломж байна гэдгийг харууллаа. Үнэлгээг 1 удаа хийгээд орхивол үр дүнд хүрэхгүй харин тодорхой хугацаанд давтамжтай хийж, түүнийхээ мөрөөр тодорхой үйл ажиллагаа явуулж байж үр дүнд хүрч болно гэдгийг бидний туршлага харуулсан юм.

Хүснэгт 3. Ил тод байдлыг хангаж ажиллаж байгаа талаар ажиллагсад болон эцэг эхчүүдийн өгсөн онооны харьцуулалт /2013 оны 04-р сар, 2014 оны 01-р сар/

Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ

Үйл ажиллагаа	2013 оны 04-р сар		2014 оны 01-р сар	
	45 багш, ажиллагсад	345 эцэг эх	68 багш, жиллагсад	447 эцэг эх / өөрчлөлтийг улаанаар тэмдэглэв
Мөрдөж байгаа хууль дүрэм журам	61-80 /57,1%/	31-60 /29,4%/	81-100 /60,3%/	81-100 /46,2%/
Санал хүсэлтийн мөрөөр авсан арга хэмжээ	81-100 /57,1%/	30-аас доош /41,2%/	81-100 /55,9%/	81-100 /39,1%/
Багш ажилчдын орсон гарсан тухай мэдээлэл	81-100 /28,6%/	30-аас доош /51%/	81-100 /70,6%/	30-аас доош /40,5%/
Багшийн ёс зүйн дүрэм	81-100 /28,6%/	30-аас доош /45,1%/	81-100 /70,6%/	81-100 /52,6%/
Төсөв болон гүйцэтгэлийн ил тод байдал	81-100 /28,6%/	30-аас доош /56,9%/	81-100 /57,4%/	81-100 /40,5%/

1

2

3

Эцэг эхээс авч буй хандив тусламжийн эргэн тайлагналт	81-100 /42,9%/	30-аас доош /41,2%/	81-100 /60,3%/	81-100 /49,0%/
Засвар үйлчилгээний мэдээлэл	81-100 /42,9%/	30-аас доош /33,3%/	81-100 /63,2%/	81-100 /44,5%/
Хөрөнгө оруулалтаар авсан бараа бүтээгдэхүүний тайлагналт	81-100 /28,6%/	30-аас доош /43,1%/	81-100 /64,7%/	81-100 /37,6%/
Хүүхдийн хоолны амт чанар, илчлэг, меню	81-100 /57,1%/	30-аас доош /29,4%/	81-100 /82,4%/	81-100 /56,4%/
Эрүүл ахуй, ариун цэвэр	81-100 /57,1%/	30-аас доош /31,4%/	81-100 /86,8%/	81-100 /60,0%/

Эцэг эх, багш нараас авсан давтан үнэлгээ нь “багш нарын орж гарсан тухай мэдээлэл”-ээс бусад мэдээллийн талаар эцэг эхчүүд өндөр оноо өгч, багш, эцэг эхчүүдийн хоорондын үнэлгээ ойртсон байна. Үйлчлүүлэгчиддээ зориулсан мэдээллийг тэдэнд сонирхолтой, энгийн байдлаар өгч чадвал эцэг эхчүүд хэрэгтэй асуудлынхаа талаар мэдээлэлтэй болсныг үнэлгээний дүнгээс харж болно.

ДӨРӨВ | ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ



Сайн арга туршлага

Цэцэрлэгийн багш ажиллагсад болон эцэг эхчүүдийн хамтарсан уулзалтаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд цэцэрлэгүүд зохион байгуулалтад орж, хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа тодорхой, бодит, хэмжигдэхүйц байх зорилго тавьсан. Бид цэцэрлэгийн захиргааны ажилтнууд, багш нараас бүрдсэн ил тод байдлыг сайжруулах баг байгуулахаас үйл ажиллагаагаа эхлүүлсэн.



Ил тод байдлыг сайжруулах баг

Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах асуудлыг хариуцсан баг байгуулж ажиллах нь уг ажлыг тогтвортой, байнга хийх, тавьж байгаа мэдээлэлдээ дүн шинжилгээ хийж, сайжруулах боломж байгаа нь харагдсан. Багт багш нараас гадна нягтлан бодогч, туслах ажилтнуудыг оролцуулсан юм. Багийн ажилтнууд мэдээллээ цахим хуудсанд тавих, мэдээллийг тогтмол хугацаанд шинэчлэх, үйл ажиллагааг зохион байгуулах гэсэн тодорхой ажил үүргийн хуваарьтай ажилласан юм.



Үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ, сонирхолд нийцсэн мэдээлэл түгээх

1

2

3

4

Төрийн үйлчилгээний анхан шатны нэгж болох цэцэрлэгийн үйлчлүүлэгчдийнхээ онцлог, тэдний сонирхол хэрэгцээнд нийцсэн мэдээллийг бүгдийг нэг мөр сайжруулах нь цаг хугацааны асуудал. Боловсролын анхан шатны нэгж болох цэцэрлэгийн үйлчилгээний үр шимийг хүртэгч эцэг эхчүүд онцлог үйлчлүүлэгчид. Өглөө ажилдаа явах замдаа хүүхдээ ангид оруулж өгнө, оройдоо ажлаасаа тарж хүүхдээ хурдан аваад гэр лүүгээ яарна, ямар мэдээлэл хаана тавьсныг төдийлөн анзаарч сонирхохгүй. Бүх мэдээллийг багшаас л сонсохыг хүснэ. Харин 20-25 хүүхэдтэй ажиллах ёстой багш маань 50-55 хүүхэдтэй өдөржингөө ажиллаад, хүн бүрт нэг бүрчлэн мэдээлэл өгнө гэдэг нь бас хэцүү. Ийм учир эцэг эхчүүд цэцэрлэгт хүүхэд нь ямар үйлчилгээ авч байна гэдэг мэдээллийг өгч байх ямар оновчтой хэлбэр байж болох вэ гэдгийг анхаарсан юм.



Мэдээлийн чанар, хүртээмжийг сайжруулах

Цэцэрлэгүүд бүгд веб хуудас нээж, болж байгаа гол үйл явдлыг мэдээлэх болсон төдийгүй. Үйл ажиллагааны ил тод байдал гэсэн цэстэй болсон.

- www.kindergarten76.mn
- www.kindergarten2.mn
- www.kindergarten189.mn
- www.kids22.mn

Мэдээллийн самбараар дамжуулан эцэг эхчүүдэд мэдээллийг энгийнээр, ойлгомжтой танилцуулах уралдаан цэцэрлэгүүдийн дунд зарласан. Уралдааныг эцэг эхчүүд шүүсэн.



Мэдээллийн ил тод байдлын талаар багш, ажиллагсад, үйлчлүүлэгчдийнхээ ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх

Мэдээллийн ил тод байдлын талаар эцэг эхчүүдийнхээ ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх цуврал сургалтууд

зохион байгуулсан. “Оролцоонд суурилсан нээлттэй цэцэрлэг” сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар эцэг эхчүүд хүүхдийнхээ ангийн самбар, цэцэрлэгийн хэмжээнд тавигдсан самбаруудад дүн шинжилгээ хийж, сайжруулах талаар санал бодлоо илэрхийлсэн. Сургалтын онцлог нь эхчүүд урьд нь самбартай зөвхөн танилцаад өнгөрдөг байсан бол самбар, цахим хуудсанд ямар мэдээлэл тавигдсан гэдэгт дүн шинжилгээ хийж, сайжруулах саналуудыг гаргасан.

Бүх цэцэрлэг “Нээлттэй цэцэрлэг” нэг сарын аян өрнүүлсэн. Аяны хүрээнд Веб хуудасны баяр, эцэг эхчүүдийн сургалт, “Шилэн түрийвч” санхүүгийн үйл ажиллагааг танилцуулах нээлттэй өдөрлөг, “Эрүүл хүнс” өдөрлөгийг зохион байгуулсан. Эрүүл хүнс өдөрлөгийн үеэр цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсэнд хэрэглэж байгаа бүтээгдэхүүнийг хаанаас авдаг хүүхдийн хоолны илчлэг, нормын талаар ойлголтоо нэмэгдүүлсэн



Хуримтлуулсан арга туршлагаасаа хуваалцах, бусдаас суралцах


Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаж байгаа туршлагаа 4 дүүргийн цэцэрлэгүүдтэй хуваалцах зорилгоор “Нээлттэй цэцэрлэг” хэлэлцүүлэг, 4 дүүргийн 110 цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч нарт “Цэцэрлэгийн Сайн засаглал ба Мэдээллийн ил тод байдал” сургалтыг зохион байгуулж хуримтлуулсан арга туршлагаасаа хуваалцсан.

1

2

3

4



ТАВ

ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эхчүүдийн оролцож байгаа байдал

“Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуульд заасны дагуу эцэг эхчүүд өөрийн ажил, мэргэжлийн онцлогийн дагуу цэцэрлэгийн үйл ажиллагаанд оролцож, дэмжиж туслах, хүүхэд сурч хүмүүжих, хөгжих сургалтын таатай орчин бүрдүүлэхэд туслахад идэвхтэй оролцдог.

Цэцэрлэгийн захиргаа нь эцэг эхчүүдийн дунд спортын наадам, зохион бичлэг, бяцхан ном, зохион бичлэгийн уралдаан зэрэг эцэг эх цэцэрлэгийн хоорондын холбоо харилцаагаа бэхжүүлэх төрөл бүрийн үйл ажиллагаа явуулж байна. Мөн эцэг эхчүүд маань хичээлийн жилийн турш хүүхдүүдийнхээ сурсан бүхнийг үзэж харах боломжтой байдагт сэтгэл хангалуун байдаг. Эцэг эхийн оролцоо үүгээр л хязгаарлагдаж байна

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулинд эцэг “Цэцэрлэгийн сургалтын орчин, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, сургалтын чанартай холбогдсон санал хүсэлт, гомдол гаргах, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар хяналт тавьж, санал гаргах, хүүхдийг сургах үйл ажиллагаатай холбогдуулан өөрөөс гаргасан зардал, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих” эрхтэй боловч ийм эрхтэй гэдгийгээ мэддэг эцэг эх цөөн байлаа.

1

2

3

4

5

Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлсэн сайн арга туршлага

Авч байгаа үйлчилгээний талаар мэдээлэлтэй байх нь үйлчилгээгээ сайжруулахад чухал ач холбогдолтой. Эцэг эх аливаа асуудлын талаар мэдээлэлтэй байх хэрэгтэй бөгөөд энэ нь эрх мэдэлтэй болж шийдвэр гаргахад оролцох боломжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй

Чанартай үйлчилгээ авахын төлөө эцэг эхчүүдийн оролцох хэрэгтэй гэдэг нь Эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн хийсэн үнэлгээ харууллаа. Хүүхдийнхээ цэцэрлэгийн сургалтын орчин ямар байгааг 4 цэцэрлэгийн Эцэг эхийн зөвлөлийн гишүүд сургалтын орчингоос зөвхөн 3 үзүүлэлтийн дагуу үнэлж үзэхэд цэцэрлэгт явж байгаа хүүхдийн эрх зөрчигдөж байгааг илрүүлсэн юм.

Хүснэгт 4. Ил тод байдлыг хангаж ажиллаж байгаа талаар ажиллагсад болон эцэг эхчүүдийн өгсөн онооны харьцуулалт/2013 оны 04-р сар /

Эцэг эхийн цэцэрлэгийн орчны зарим стандартад хийсэн үнэлгээ

Шалгуур үзүүлэлт	Норм норматив	Бодит байдал	Үр дагавар, эрсдлүүд
Нэг ангид байх ёстой хүүхдийн тоо	20-25	36-54 хүүхэд 1 ангид хүмүүжиж байна	Багш 2 дахин их ачаалалтай ажиллаж байгаа учир хүүхэд нэг бүрт хүрч ажиллах, анхаарал тавих боломжгүй үүнээс үүдэлтэй хүүхдийн аюулгүй байдлын эрсдэл нэмэгдэнэ
1 хүүхдэд ноогдох талбай	Дунджаар 2,5 м2	Нэг хүүхдэд ноогдох талбай 2-2,4 дахин бага	Агааржуулалтын төхөөрөмж байхгүй, цонх онгойлгож агааржуулдаг учир өвлийн цагт хүүхэд ханиад хүрэх магадлал өндөр. Бүгчим, чийгтэй, амьсгалын замаар дамжих халдварт өвчин гарах эрсдэлтэй, хүүхдийн хөгжил,, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх магадал өндөр. Хүүхдийн хэвийн хөдөлгөөн хязгаарлагдсан учир биеийн хөгжлийг саатуулах эрсдэлтэй.

Суултуур	8 хүүхдийн дунд 1/ стандартын дагуу нэг ангид байх хүүхдийн тоотой харьцуулан тооцов/	12-16 хүүхдэд 1 суултуур ноогдож байна	Эрүүл ахуйн шаардлага хангасан орчин алдагдаж, бохиртож, багшийн ачааллыг нэмэгдүүлдэг, халдварт өвчин тусах эрсдэл өндөр, бие биенээ удаан хүлээх зуур өмдөндөө бие засах, өндөр эрсдэлтэй.
----------	---	--	--

Эцэг эхчүүд сургалтын орчингийн дээрх наад захын шалгуурын дагуу үнэлгээ хийхэд л цэцэрлэгийн хүүхдүүдийн эрүүл, аюулгүй орчинд сурч хүмүүжих эрх ноцтой зөрчигдөж байна. Ийм учир цэцэрлэгийн эцэг эхчүүд түүний дотор Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны нэг чиглэл бол хүүхдийнхээ авч байгаа үйлчилгээний талаар мэдээлэл байнга авах, үйлчилгээ ямар байгаад хяналт тавьж, дутагдлыг сайжруулахыг шаардах, хүүхдийнхээ авч байгаа үйлчилгээний чанартай холбоотой шийдвэр гаргахад оролцох оролцоог нэмэгдүүлэх боломж байна.

ДҮГНЭЛТ

Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг сайжруулах чиглэлээр хамтарч ажилласан цэцэрлэгүүдэд сайн засаглалтай болох эрмэлзлэл хэвшсэн төдийгүй өөрийн үйл ажиллагаа, хүний нөөц, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ил тод болгохын зэрэгцээ төсөв санхүүгийн төлөвлөлт, хэрэгжилтэд эцэг эхчүүдийн оролцоог хангах ажлуудыг хийх эрмэлзлэлтэй болж хууль хэрэгжүүлэх сэтгэлгээ хандлагад мэдэгдэхүйц өөрчлөлт гарлаа.

Сайн засаглалын бас нэг бүрэлдэхүүн хэсэг болох хууль, эрх зүйн хүрээнд тус цэцэрлэгүүд үйл ажиллагаагаа явуулах ажлыг хэвшил болгохын тулд оролцоонд суурилсан сургалтууд явуулах, холбогдох хууль эрх зүйн актаар гарын авлага бэлтгэн өгч хуулийн хэрэгжилтээр дүрийн тоглолт хийх, нүүр тулсан уулзалтаар мэдээлэл хүргэх, энгийн ойлгомжтой байдлаар төсвийн хуулийг мэдээллийн самбараар дамжуулан сурталчлах гэх мэт ажлуудыг хийсэн нь эцэг эхчүүд болон багш ажилтнууд хуулийг хэрэгжүүлэхэд оролцоотой байх ёстойгоо ойлгоход чухал алхам болсон юм.

Эцэг эхчүүд оролцоо, идэвхи санаачилгаар цэцэрлэг дээр олон зүйлийг өөрчилж болно гэдэг итгэл үнэмшилтэй болж байна. Цэцэрлэг дээр байх ёстой олон стандарт, норм зөрчлийг арилгахад эцэг эхийн оролцоо чухал гэдэг нь эцэг эхчүүдийн ойлголт мэдлэгүүдийг нэмэгдүүлж чадлаа.


АШИГЛАСАН МАТЕРИАЛ: _____

Нэг. Хууль эрх зүйн баримт бичиг


- Монгол Улсын Үндсэн хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 17 дугаар тогтоолоор “Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”
- Сургуулийн өмнөх боловсролын талаар баримтлах бодлого (Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 17 дугаар тушаал)
- Бага насны хүүхдийн хөгжилд эцэг эх, гэр бүл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас баримтлах чиглэл (Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 17 дугаар тушаал)
- “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм(Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 41 дүгээртүшаал
- Цэцэрлэгийн хүүхдийн эцэг, эхээс нэг жилд бэлтгүүлэх хичээлийн хэрэглэгдэхүүний жагсаалт (Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн А/266дугаар тушаалын хавсралт)
- Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламж-Барилгын норм ба дүрэм БНБДИ -66-88

Хоёр.Бусад материал

- Сайн засаглал ба хариуцлага. Хүүхдийн тусламжийн утсыг боловсронгуй болгох гарын авлага (Нийслэлийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газар)
- Сургуулийн өмнөх боловсролын нөхцөл байдлын тойм судалгаа (БШУЯ, Азийн хөгжлийн банк) 2011 он
- Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээ(БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн Сан, МУИС),2013 он
- Хүүхдэд ээлтэй цэцэрлэг төсөл(Японы Хүүхдийг Ивээх сан),2013 он
- 22-р цэцэрлэгийн гарын авлага
- 6. 2, 22, 76, 189-р цэцэрлэгийн мэдээллийн самбарууд, цахим хуудас, сургалтын материалууд, эцэг эхчүүдтэй хийсэн уулзалтуудын тэмдэглэл гэх мэт



Монгол улс, Сүхбаатар дүүрэг,
6-р хороо, Бага тойруу,
48-р байр, 305 тоот
Шуудангийн хаяг: Улаанбаатар-46А, ШХ 280

Утас/факс: 976 -7711 9991
И-мэйл: mones@mongol.net, info@mones.org.mn
Веб: www.mones.org.mn
 Mongolian Women's Fund
 mones2013